



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 01 өдөр

Дугаар А/414

Арвайхээр

Албан татвар, хүү торгуулийн орлогыг
орон нутгийн төсөвт төвлөрүүлэх, хууль сурталчлах
арга хэмжээг эрчимжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1, Монгол Улсын Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 8 дугаар зүйлийн 8.2, Өршөөл үзүүлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, агаарын бохирдлын төлбөр, орон нутгийн зам ашигласны хураамж, бусад орлогыг ард иргэдэд сурталчлах, албан татварын хууль, хувь хэмжээг таниулах ажлыг зохион байгуулах, татварын орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлж, татвар хураалтын ажлыг эрчимжүүлэхийг аймгийн Татварын хэлтэс (Н.Эрдэнэсүвд)-т үүрэг болгосугай.

2.Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон хууль, тогтоомж зөрчсөн этгээдэд бэлэн бус торгууль ногдуулах хууль тогтоомжийн биелэлтийг хангаж, орон нутгийн хэмжээнд хяналт, шалгалтын цэгүүдэд хамтарсан ажлын хэсэг гаргаж, хуулиар ногдуулсан татвар болон бусад хүү торгуулийн төлбөрөө хугацаандаа барагдуулаагүй иргэн, хуулийн этгээдийн бүртгэл судалгааг гаргаж, зөрчлийг газар дээр нь арилгаж, орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхийг аймгийн Цагдаагийн газар (цагдаагийн хурандаа Б.Мөнх-Эрдэнэ), аймгийн Засаг даргын дэргэдэх Татварын хэлтэс (Н.Эрдэнэсүвд)-т тус тус үүрэг болгосугай.

3.Дээрх арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулж, удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллах, тайлан мэдээг 2021 оны 09 дүгээр сарын 30-ны дотор танилцуулж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (И.Доржсүрэн)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011100882